



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/402

Арвайхээр сум

Зардал хуваарилж, эрх шилжүүлэх
тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөв батлах” 15/06 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалтын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Аймгийн 2023 оны төсөв батлах” 15/06 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1 дэх заалтад тусгагдсан “Орон нутгийн чанартай авто замын засвар арчлалт” төсөл арга хэмжээний зардал 295,750,000 (хоёр зуун ерэн таван сая долоон зуун тавин мянга) төгрөгийг хавсралтад зааснаар зарцуулсугай.

2.Хавсралтын 2, 3, 6, 7 дугаарт тусгагдсан ажлуудын эрхийг Хайрхандулаан, Арвайхээр, Хархорин сумдын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

3.Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т, Хайрхандулаан сумын Засаг дарга (П.Алтанган), Арвайхээр сумын Засаг дарга (Б.Ганбат), Хархорин сумын Засаг дарга (Г.Одгэрэл) нарт тус тус даалгасугай.

4.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0782

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 20-ны өдрийн 170 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Сумын нэрс	Санхүүжилтийн дүн (төгрөг)
1	Тэмүүлэл Эрдэм сургуулийн авто зогсоол	84,000,000
2	Хархорин сумын авто замын нөхөөс	20,000,000
3	Хархорин сумын авто замын хэвтээ тэмдэг, тэмдэглэгээ	15,000,000
4	Арвайхээр сумын авто замын нөхөөс, авто замд гагнаас хийх (зун)	52,550,000
5	Арвайхээр сумын авто замын нөхөөс, авто замд гагнаас хийх (намар)	50,000,000
6	Хайрхандулаан сумын гурван голын гүүрний засвар	8,500,000
7	Арвайхээр сумын 4-р цэцэрлэгийн авто зогсоол	45,700,000
8	Арвайхээр сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээ	20,000,000
	Нийт	295,750,000

-оОо-